



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Сээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, 2018 оны I улирлын ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулж, биелэлтийг тооцон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд улирал бүр танилцуулж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /М.Азжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Н.БАЗАРРАГЧАА





ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 08

Сээр

Төсөл дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9, 20.1.10 дахь заалтууд, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төлөөллийн болон хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх санал, санаачлагыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах "Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах нь" төслийг дэмжсүгэй.

2.Төсөл хэрэгжүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Н.Базаррагчаа - ИТХ-ын Дарга

М.Азжаргал - ИТХ-ын Нарийн бичгийн дарга

Т.Дариймаа - Тэргүүлэгч

Н.Азжаргал - БИНХ-ын дарга

Ө.Энхцэцэг - Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн

У.Тунгалаг - Ахмадын хорооны тэргүүлэгч

Д.Пүрэвсүрэн – Малчин

3.Тус төслийг удирдамжийн дагуу боловсруулан, хянан үзэж, холбогдох газарт хүргүүлэхийг төсөл хэрэгжүүлэх багийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.БАЗАРРАГЧАА





ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 03

Сээр

Тодорхойлолтыг дэмжих тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын Агваш багийн ахмад настан Чоёнгийн Лхагвын сум орон нутгийн хөгжилд оруулсан хөдөлмөр бүтээл, амжилтыг тодорхойлон “Алтан гадас” одонгоор шагнуулахаар дэмжсүгэй.

2.Агваш багийн ахмад настан Ч.Лхагвыг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар Монгол улсын ерөнхийлөгчид өргөн мэдүүлж өгөхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргад хүссүгэй.

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 04

Сээр

Хяналт, шалгалтын төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Хороод, Ажлын албаны 2018 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулж, хяналт шалгалтыг сайжруулан, үр дүнд хүрч ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Н.Базаррагчаа/-д даалгасугай.

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 05

Сээр

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Сумын аварга малчин шалгаруулах" журмыг нэгдүгээр хавсралтаар, малчны тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар, малчны ажлын үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Заяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 06

Сээр

Шагнуулах тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 116 дугаар зарлигаар баталсан эхчүүдэд “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одон шагнах журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг үндэслэн, сумын Засаг даргын саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дөргөн сумын “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.”Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг хянан үзэж, Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж өгөхийг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д хүссүгэй.

ДАРГА  Н.БАЗАРРАГЧАА





ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 07

Сээр

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын “Сангийн далайн давсны орд газрыг ашиглах, хамгаалах” журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга Г.Заяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.БАЗАРРАГЧАА





ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 10

Сээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.14 дэхь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Заяа/, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч /Б.Түвшинжаргал/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 11

Сээр

Өрхийн нэрс батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолын хавсралтын 6 дугаар зүйлийн 6.4.2 дахь заалтууд, сумын Засаг даргын саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын хөгжил, хамгааллыг сайжруулах зорилтот өрхийн нэрсийг сонгон хавсралтаар баталсугай.

2.Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах арга хэмжээг авч, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Заяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА